



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 25 өдөр

Дугаар 406

Улаанбаатар хот

“Автотээврийн үндэсний төв”  
төрийн өмчит үйлдвэрийн газрын  
2018 оны төлөвлөгөөнд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан MNS 4410-2:2017 стандартыг хэрэгжүүлэх, зарим аймгийн автотээврийн төвийн барилгын зураг төсөв хийлгэх, барилгын эвдрэлийг засварлах шаардлага үүссэн зэргийг харгалзан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 651 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний “...хөрөнгө оруулалт 5,707,967.7 мянган төгрөг” гэснийг “...хөрөнгө оруулалт 6,057,287.7 мянган төгрөг” гэж өөрчилсүгэй.


2. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд өөрчлөлт орсонтой холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 651 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хавсралтад заасан төсөл, арга хэмжээг нэмсүгэй.

3. Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг захирал П.Дэлгэрнаранд даалгасугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002233

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн  
406 дугаар тогтоолын хавсралт

**“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД  
НЭМЭГДЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ**

№	Нэр, төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж бүрийн үнэ	Нийт үнэ /мян.төг/
<b>22. Дундговь аймгийн автотээврийн төвийн автовокзалын барилгын гадна фасадын ажил</b>					
1	Дундговь аймгийн автотээврийн төвийн автовокзалын барилгын гадна фасадын ажил	Багц	1	69,060	69,060.0
<b>23. Увс аймгийн автотээврийн төвийн техникийн хяналтын барилгын зураг төслийн ажил</b>					
1	Увс аймгийн автотээврийн төвийн техникийн хяналтын барилгын зураг төслийн ажил	Багц	1	22,000	22,000.0
<b>24. Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдгийн лац</b>					
1	Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдгийн лац	Ширхэг	400	363	145,000.0
<b>25. Баян-Өлгий аймгийн автотээврийн төвийн техникийн хяналтын барилгын зураг төслийн ажил</b>					
1	Баян-Өлгий аймгийн автотээврийн төвийн техникийн хяналтын барилгын зураг төслийн ажил	Багц	1	9,500	9,500.0
<b>26. Зөвлөхийн бус үйлчилгээ үзүүлэх</b>					
1	Зөвлөхийн бус үйлчилгээ үзүүлэх /Олон Улсын гэрээ, конвенц орчуулах, баталгаажуулах/	Багц	1	23,760	23,760.0
<b>27. Суудлын авто машин худалдан авах</b>					
1	Улс хоорондын тээвэрлэлт гүйцэтгэдэг хилийн боомттой салбаруудад шаардлагатай суудлын авто машин худалдан авах	Ширхэг	1	80,000	80,000.0
<b>Бүгд дүн</b>					<b>349,320.0</b>

1. Гэрээний явцын төлбөр					
3	Баян-Өлгий аймгийн битүү захын 40 хувийг УИХ-ын 2018 оны 60 дугаар тогтоолоор “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т шилжүүлсэнтэй холбоотой лангуу түрээслэгч болон орон нутгийн хөгжүүлэх санд буцаан төлөх шаардлагатай төлбөр	Багц	1	143,043	143,043.0
<b>Нийт дүн</b>					<b>143,043.0</b>